

ARTICLE

Монгол ардын үлгэр ба сторителлинг: Өв, уламжлал, хэрэглээ

Аюушжавын АЛИМАА\*<sup>1</sup>

Монгол Улс, Улаанбаатар,  
Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн,  
Аман зохиол судлалын салбар,  
Email: [alimaaa@mas.ac.mn](mailto:alimaaa@mas.ac.mn),  
<https://orcid.org/0000-0002-3533-2000>

Баасанжаргалын ДАЙРИЙМАА<sup>1</sup>

Монгол Улс, Улаанбаатар,  
Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн,  
Аман зохиол судлалын салбар,  
Email: [Dairiimaab@mas.ac.mn](mailto:Dairiimaab@mas.ac.mn)  
<https://orcid.org/0000-0001-6929-7664>

**Received:** September 27, 2025 | **Accepted:** December 15, 2025 | **Published:** December 30, 2025

**Хураангуй:** Сторитэлингийн үндсэн эх сурвалж бол ардын үлгэр, домог, хууч хэлэх уламжлал төдийгүй өнөө цагт аман зохиолыг сурталчлах, хөгжүүлэх өргөн боломж юм. Тиймээс өгүүлэлд сторитэлингийн талаар товч өгүүлж түүнийг монгол аман зохиолын өвөөс үлгэр, домог, хууч яриаг сторитэлингийн чиглэлээр хөгжүүлэх боломжийн талаар санал дэвшүүлжээ. Чингэхдээ үлгэр, домог буюу миф, түүхэн домог, хууч зэрэг дарааллаар тайлбарлан бичсэн байна. Өгүүллийг бичигчид ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиолын хөмрөгт байгаа аман зохиолын сторитэлингт хамаарч болох төрлүүдийн талаарх эх сурвалжийн тоо баримтыг дурдаж тэдгээр нь сторитэлингийг хөгжүүлэх эх суурь гэж үзжээ.

Аман үгийн өв, уламжлалт урлагийн баялаг суурь дээр тулгуурлан сторитэлингийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, түүгээр дамжуулан аман зохиол, түүний төрөл зүйлүүдийг олон нийт, залуу үед таниулан сурталчлах нь орчин цагт нэн ач холбогдолтой гэдгийг өгүүлжээ.

**Түлхүүр үг:** аман зохиол, эх үндэс, үлгэр хэлэх уламжлал, хэрэглээ

<sup>1</sup> ©, Зохиогч(ид), 2025; \* - Холбоо барих зохиогч

## **Mongolian Folktales and Storytelling: Heritage, Tradition and Application**

*ALIMAA Ayushjav  
Department of the Folklore Studies,  
Institute of Language and Literature,  
Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia*

*DAIRIIMAA Baasanjargal  
Department of the Folklore Studies,  
Institute of Language and Literature,  
Mongolian Academy of Sciences,  
Ulaanbaatar, Mongolia*

**Abstract:** *The main sources of storytelling are not limited to folk tales, legends and narrative practices, they also include the wide opportunities available today for promoting and developing oral literature. Therefore, the article briefly describes storytelling and explores the potential for developing folk tales, legends, and myths from the heritage of Mongolian folklore within the field of storytelling. The authors considered the following sequence: fairy tales, legends or myths; and historical legends and fairy tales.*

*The authors of the article cite data on folklore genres that can serve as a foundation for the development of storytelling, drawing on the folklore collections of the Institute of Language and Literature of the Mongolian Academy of Sciences as their source. It is noted that in the modern era, developing the art of storytelling, introducing it into practice, and using it to familiarise the general public, especially young people with folklore and its varieties is of great importance.*

**Keyword:** *Mongolian folklore, storytelling, tales, Mifhology, old talks*

### **Удиртгал**

“Сторитэлинг” хэмээх нэр томъёог 1992 онд Armstrong International компанийн гүйцэтгэх захирал, эртний гүн ухаан судлаач Дэвид Армстронг (David Armstrong) “Managing by Storying Around: new method of Leadership” номдоо анх хэрэглэсэн бөгөөд номд ямар нэг байгууллагын ажилтнууд ажил төрлөө сурталчлах, зааварчилгаа өгөхдөө хуурай (жирийн) тайлбарлах, уйтгартай танилцуулга үзүүлэхийн оронд сонирхолтой түүх ярих нь илүү үр дүнтэй, тэгэхдээ тодорхой нөхцөлийг зөв тооцоолж, оновчтой ярих талаар өгүүлсэн нь орчин үед ганц бизнесийн салбараар тогтохгүй чухал чиглэл болж байна. Д.Армстронг компанийн ажилчид эгзэгтэй нөхцөл байдлаас хэрхэн гарч, бэрхшээлийг даван туулж, үнэнч үйлчлүүлэгчидтэй болсон тухай ер бусын гэмээр түүхийг цуглууулж түүнээ оновчтой ашиглажээ. Өдгөө энэхүү ойлголт бизнес, маркетингийн хүрээнээс хальж сургалт, судалгаанд өргөн ашиглагдахаас гадна орчин үеийн мэдээлэл, PR, боловсрол, сурган зүй, хэл засал, ой тогтоолт зэрэг эмчилгээний олон урсгалын нэг болжээ.

Азийн улс орнууд Азийн Сторитэлингийн холбоонд нэгдэж төрөл бүрийн фестиваль, тоглолт, үлгэрчдийн туршлага солилцоог зохион байгуулдаг бол манай улсын шинжлэх ухааны байгууллагын мэргэшсэн судлаачдын оролцоо үндсэндээ байхгүй байгаа нь энэ асуудлыг авч үзэх шалтгаан билээ.

Сторитэлинг буюу түүх ярих урлагийг аман зохиол, ардын үлгэрийн бүтэц, зохиомжоос эх аван, зан үйлийн зарим элементүүдийг дагалдуулан хөгжүүлэх, монгол үлгэрч нарыг тодруулах, авьяасыг дэмжин урамшуулах нь өдгөө оюуны соёлоо уламжлан хамгаалах тулгамдсан асуудлуудын нэг болоод байгаа нь энэхүү өгүүллийг бичих гол үндэслэл болов.

Цахим эрин үе хүмүүст мэдлэг хуваалцах, хадгалах боломжийг нээсэн нь үлгэрч нарт аман зохиол, аман түүхээ тархаан хөгжүүлэх, таатай нөхцөл болж digital storytelling хэдийнээ үүссэн, төдийгүй сторитэлингийг янз бүрийн сургалт, хүмүүжил, эмчилгээний чиглэлээр өргөн ашиглаж байна. Тухайлбал, Австрали улсад хүүхдүүдийн хэт хөдөлгөөний эмгэгшил (hyperactivity)-ийг зөв залуурдах арга зүйг сэтгэл зүйч Майкл Уайт боловсруулсан зэрэг жишээг дурдаж болно. Иймд өгүүллийн зорилго нь сторитэлингийг Монгол Улсад хөгжүүлэхэд шинжлэх ухааны үндэслэл, мэргэшсэн байгууллага, судлаачдын оролцоог тодорхойлоход оршино.

Зорилготой уялдуулан уг ухагдахууныг тайлбарлах, нэр томъёог хэвшүүлэх талаар саналыг дэвшүүлэх, өөрсдийн боломж, нөөцийг танилцуулах, хөгжүүлэх арга замыг өгүүлэх болно.

**Судалгааны тойм:** Сторитэлинг буюу үлгэр, түүх ярихуй нь хүн төрөлхтөн хэлтэй болохоос ч өмнө үүссэн гэж үздэг бөгөөд хад чулуу зэрэгт зурж үлдээсэн дурсгал бидэнд түүх өгүүлдэг. Гэрэл болон уран зураг, кино, радио, зурагт, компьютер, интернэт зэрэг олон нийтийн мэдээллийн хэрэгслээс гадна эмээ өвөө, эцэг эх, багш, сурган хүмүүжүүлэгчид зэрэг хүн бүхэн бидэнд түүх яригчид байдаг бол илүү мэргэшсэн хүмүүс бол үлгэрч, туульч, хуурч нар юм. Тэд үлгэр, түүхийг өөрсдийн сурснаар өгүүлэхээс гадна өөрсдөө зохион сэтгэмжилж хүүрнэн өгүүлдэг. Сторитэлинг гэх нэр томъёо 1985 онд нийтийн соёлтой холбоотойгоор анх дурсагдсан байна.

1928 онд хэвлэгдсэн В.Проппын “Шидэт үлгэрийн бүтэц” сторитэлингийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн нь үлгэрийг задлан шинжлэх арга: дүрүүдийн зан чанар, үүрэг, ид шид, түүний хэрэгсэл, нөхцөл байдлыг тодорхойлж өгсөн билээ. Дараа дараагийн судлаачид Жозеф Жон Кэмпбель, Блейка Снайдер (“Нохойг авар!”), Сандра Филд нар үлгэрийн бүтэц зохиомжийн судалгааг гүнзгийрүүлж, нэг ёсондоо сайтар ойлгох томъёоллыг гаргаж ирсний сацуу сайхан түүх бүтээх гол зарчмыг боловсруулсан байдаг. Үлгэрийг хэрэглээнд нэвтрүүлэх талаар судалгаа болон хөгжүүлэлт өргөн хийгджээ. Тухайлбал, Дэн Симмонс авьяаслаг хүүхдийг хөгжүүлэх АРЕХ хөтөлбөрийн хүрээндээ хагас жилийн турш “Гипериона”-ын түүхийг ярьж, өөрөө түүх зохиох явцдаа, Марк Лоуренс хүнд өвчтэй охиноосоо сэдэл авч үлгэрлэг зохиолуудаа бичсэн зэрэг нь сторитэлингийн хөгжилд томоохон нөлөө үзүүлжээ. Тэр ч байтугай бизнесийн үлгэрийн хэрэглээ бий болсон байна.

2018 онд Азийн Сторитэлингийн холбоо (FEAST) байгуулагдсан бөгөөд үндсэн зорилгуудын тоонд өөрсдийн оюуны өв соёлоос хуваалцах, мартагдсан

түүхүүдээ сэргээн ярих, дэлгэрүүлэх, Азийн улс түмний асар баян соёл, урлаг, үгийн урлагийг дэлхий нийтэд таниулах зэрэг багтаж байгаа юм. 2025 онд 17 дахь удаагийн хурлаа Монгол Улсад хийж бүс нутгийн хүрээнд соёлын солилцоог хөгжүүлэх арга зам, монгол аман зохиолын ач холбогдлыг ярилцжээ.

Сторитэлинг хөгжсөн улс орны түүхийг үзвэл (Ирланд, Солонгос, Америк) ардын үлгэр, домог, хуучид суурилсан байх ба түүнийгээ уламжлалт “сторитэлинг” гэж нэрлэнэ. Өдгөө сторитэлинг дуу, цаас, дүрс, цахим, комикс, олон нийтийн мэдээллийн хэрэгслийн гэх мэтээр ялган хөгжиж байна. Манай улсын хувьд дуу, дүрс, FM-ийн хэлбэртэй байгаа бол хүүхдийн зохиолч О.Сундуй, зураач Ли Ерин (БНСУ) нарын “Хадны зургийн ертөнцөөр аялсан нь” (2025) зурагт ном Азийн сторитэлингийн хөтөлбөрийн хүрээнд хэвлэгджээ.

Мөн Монгол Улсад хөгжиж эхэлсэн сторитэлингийн үйл ажиллагаа нь төдийлөн нийтийг хамраагүй, судлаачдын оролцоо бага, үндсэн суурь, эх сурвалж хаана, юунд оршиж байгаа талаар мэдээлэл хомс зэрэг асуудлуудыг шат дараатай шийдэж, хэрэгжүүлж явах нь чухал юм.

**Судалгааны арга зүй:** Ардын аман билгийг мартагдахаас сэргийлэх, уламжлалыг сэргээн сануулах ач холбогдолтой тул аман зохиолын онол, үлгэрийн онолын бүтээлүүдэд тулгуурлав.

Сторитэлингтэй холбоотой сүүлийн үеийн хандлагуудыг харахад маркетинг, сурталчилгааны зорилгоос гадна ямар нэгэн гадаад хэл сургах стратеги, дунд сургуулийн боловсролд түүнийг хэрхэн ашиглах боломжуудыг хайсан, ярих урлаг, туршлага суулгах, нийгэм, соёлын харилцааны гол цөм болсон медиа, мэдээллийн орчин дахь хувь хүн өөрийгөө илэрхийлэх, цаашилбал сэтгүүл зүй, музей, театр зэрэг өргөн хүрээг хамарч байгаа тул соёлын харилцааны онолыг гол болголоо.

**Судалгааны таамаглал:** Ардын үлгэр, домог, хууч яриа нь тогтмол бүтэц, зохиомж, хэлбэр зэргээрээ сторитэлингийг ямар ч чиглэлээр хөгжүүлэх үндэс суурь болно. Монгол үлгэр, туулийн амин сүнс болсон үлгэрч, хуурч, туульч нарын сэтгэл зүй, сэтгэл хөдлөлийн онцлог нь ярих (хүүрнэх, урлаг-стротэлингийг хөгжүүлэх баялаг туршлага юм.

**Судалгааны үндсэн хэсэг:** Сторитэлинг бол *зорилго, өгүүлэмж, дүр, өрнөл, зөрчил, шийдэл* гэх мэт өөрийн гэсэн бүтэц, зарчимтай байх агаад түүний өвөг хэлбэр нь жинхэнэ ярих урлаг, түүх өгүүлэхүйг агуулж буй үлгэр, домог юм хэмээн үзэж болно. Ардын үлгэр бол хүн төрөлхтний туйлын хүслэн болсон баатар, түүний баатарлаг үйлийг магтан дуулсан, аз жаргалтай төгсгөлийг бэлгэдсэн, олон зууны турш амаас ам дамжин уламжлагдахын хэрээр нийгэм, сэтгэлгээний өөрчлөлтийг даган сэдэв, өгүүлэмжийн хувьд баяжсаар иржээ.

Дээрх үндэслэлийн хүрээнд монгол сторитэлингийн уламжлал ба монгол ардын үлгэр сторитэлингийн эх сурвалж болох тухай, сторитэлингийг хөгжүүлэх суурь шинжтэй боломжийн талаар монгол үлгэрийн сан, хөмрөгт тулгуурлан авч үзэж болох юм.


1921 онд Судар бичгийн хүрээлэнгийн тэргүүлэгчдийн санаачилгаар Дуун ухааны тасаг байгуулагдаж “байгуулагдсан цагаасаа эхлэн эхний 10 жилд юуны

урьд хэлбичиг, утга зохиолын шинжлэгдэхүүний материалыг цуглуулан бүртгэх ажилд гол анхаарлаа тавин ажилласан” (УТА, Ф-23, Д-2, ХН-87) байна.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиол, нутгийн аялгууны сан хөмрөг ардын аман зохиолын бүхий л төрөл зүйлийг хамарсан баялаг цуглуулгатай. Мөн судлаачдын зүгээс шууд өвлөн уламжлагчаас тэмдэглэж авсан ямар нэг засвар ороогүй анхны эх гар бичмэлээр хадгалагдан байгаагаараа эрдэм шинжилгээний асар их үнэ цэнтэй билээ. Жишээ дурдахад: 1955.07.1-1955.8.23-ны хугацаанд Сүхбаатар аймгийн Түвшинширээ, Хонгор, Онгон, Дариганга суманд ажиллаж үзэмчин, хуучид аман зохиол, Чойбалсан аймгийн Хэрлэн, Хөлөнбуйр сумдаас барга аман зохиол, Баян суманд зүүн үзэмчний аман зохиол, Хэнтий аймгийн Дархан, Баянмөнх, Чойбалсан аймгийн Тамсаг, Матад, Хөгнө сумаас халх аман зохиол цуглуулсан болохыг илтгэжээ. Уг шинжилгээний анги халх, дариганга, баруун, зүүн үзэмчин, барга, авга ардын ардын дуу үлгэр, ерөөл, ертөнцийн үг зэрэг нийт 2300 гаруй хуудас хэрэглэгдэхүүн цуглуулсан байдаг. Зөвхөн үлгэр гэхэд “богино үлгэр-49, дунд зэргийн үлгэр 22, урт үлгэр 26 цуглуулсны дотор шинэ үед зохиосон маш сонирхолтой үлгэр хэд бий” (УТА. Ф-23, Д-2, ХН-87) хэмээн тэмдэглэжээ.

Монголчууд *түүх ярихуйн* талаар эртний уламжлалтай. Энэ уламжлалыг монгол аман зохиолын төрөл зүйлийн тогтолцоог харахад тодорхой болно.

*Зураг 1. Монгол аман зохиолын төрөл зүйлийн бүдүүвч ангилал*



Дээрх хүснэгтээс монголчуудын сторитэлингийн уламжлалд домог үлгэр (myth), үлгэр (fairytale), түүхэн домог (legend), хууч домог (historical story), аман хууч яриа (old talk) гэсэн төрлүүд хамаарагдаж байна.

Үлгэр нь дотроо аман буюу уламжлалт үлгэр, зохиолын буюу уран зохиолын үлгэр (зохиогчтой үлгэр) гэж хуваагдах бол уламжлалт үлгэр нь адгуус амьтны үлгэр, шидэт ба баатарлагийн үлгэр, аж байдлын үлгэр гэх үндсэн гурван дэд зүйлд хуваагддаг.

Уламжлалт үлгэрийн нэгэн төрөл болох **домог үлгэр** [миф] бол *түүх ярихуйн* үндсийн үндэс гэж болно. Андри Гуревич “World Mythology: Myth, Metaphor and Mystery” номдоо “Myths symbolize human experience and embody the spiritual values of a culture” буюу “Домог нь хүний туршлагыг бэлгэдэж, оюун соёлын үнэт зүйлсийг агуулдаг” (Gurevich, 2008: 3) гэсэн бол нэрт судлаач Мирча Элиаде “Домог бол цаг хугацааны эхэн үед болсон явдлын үнэн түүх бөгөөд хүний амьдралын мөрдлөг, үлгэр дуурайл болдог ариун нандин, үнэн түүх” Элиаде (1996: 22) гэсэн нь хуучны, нэн эртний, хий хоосон зүйл гэдгээс өөр тодорхойлолт юм. Түүнчлэн, Домог нь бүх эхлэлийн эхлэл, мартагдашгүй цаг үед тохиолдсон үйл явдлын тухай ариун түүх, хүн төрөлхтний тодорхой “бүтээлийн” тухай түүх, хүн өөрөө домог гэхчлэн мөн чанарыг нь тайлбарласан билээ. Домогийг эрт балар цагийн хүмүүсийн *гэнэн тайлбар* бүхий үлгэр гэдэг тодорхойлолт нэгэнт хуучирсан нь домог зүйн судалгаа ихээхэн урагшилсныг харуулдаг. Тухайлбал, домог өнөө үед, одоо ч бидний дотор оршин байгаа бөгөөд түүний шалтгааныг багцалж үзвэл:

1) Ер бусын амьтдын түүх, гавьяаны түүхийг өгүүлдэг тул хүмүүсийн анхааралд оршдог. Жишээ нь, нэгэн цагт огторгуйд 7 нар мандаж түүний зургааг нь харваж нэг нартай үлдээгээд өөрөө тарвага болсон Эрхий мэргэний домог нь бодит байдалтай нэлээд нийцтэй сэтгэгдэл төрүүлдэг. Тухайлбал, монголчууд тарвагыг (*Marmota bobak*) хүнтэй төслүүлж ярих нь олон. Үүнд, тарваганы урд сарвуу дөрөв (харин хойд сарвуу таван хуруутай) байдаг нь Эрхий мэргэн нэг нарыг алдсанаас эрхий хуруугаа тайрч хаяснаас болсон гэнэ. Тарваганд хүн мах гэж идэж болдоггүй мах байдаг бөгөөд якутчууд мөн адил түүнийг иддэггүй. “Якутын анчид тарваганы урд мөчдийн хоёр суганд байрлах булчирхайг авч хаях хэрэгтэй гэдэг” (Якутын аман зохиолч Иван Васильевичээс тэмдэглэж авав. Алимаа 2020 оны 9 сард. Якутск хот). Өөр бүл тарваганууд газар нутгийн эзэмшлээс мөн, мөндлүүд цатгалан үедээ барилдах мэт ноололдох ба үүнийг монгол бөхийн барилдааны үүслийг холбон ярилцах нь бий.

2) Домог нь зарим талаараа “үнэн” байдаг тул домог өөрөө ер бусын, тайлбарлагдашгүй юм. Зарим тохиолдолд домог батлагдах мэт байдаг (галав юүлэх тухай ойлголт, хорхойн дайралт болох г.м). “Эрхий мэргэний домог”-т Эрхий мэргэн мэргэн харваач гэж алдаршсан ч нэг нарыг харваж чадаагүйдээ гэмшиж, эрийн тангараг ёсоор хар ус уухгүй, хагд өвс иддэг амьтан болж хар нүхэнд амьдардаг болсон гэж гардаг.

3) Орчин үед, одоо ч домог бүтээгдсээр байгаа. Жишээ нь, шашны бус итгэл үнэмшилтэй холбоотой домог (Нисдэг, үл мэдэх биетүүд, харь гарагийнхны тухай домог, алмасын тухай, олон хүнийг хамруулан экстрасенс хийдэг эмч нар гэх мэт). Мөн нийтийн соёлын домог гэх зүйл бий. Жишээлбэл, Америк амьдралын хэв маяг, орчин цагийн хүүхэлдэйн түүхээс Гонконгийн зураачийн (*Kasing Lung*) бүтээсэн бяцхан мангас *Labubu*-г дурдаж болно.

**Үлгэр** бол домгоос ялгаатай нь хэтийдсэн уран сэтгэмж, уран яруу илэрхийлэл, мөрөөдөл хүслэнгийн үзэл санаа давамгайлсан байна. Өдгөө тус Аман зохиолын сан хөмрөгт бичмэл буюу цаасан хэлбэртэй **97** хавтас бүхий **1465 үлгэр**, соронзон бичлэгийн 257.48 цагийн **625 үлгэр** хадгалагдаж байна.

Монгол хүн болон анчид гөрөөчид, жин тээгчид оройдоо үлгэр, домгийн цагтай байсан бөгөөд үлгэр ярихын өмнө тусгай зан үйл гүйцэтгэж ярих ба үлгэрч хамгийн сонирхолтой хэсэгт ирээд “*маргааш үргэлжлүүлэн ярья. Одоо шөнө болж шүлэг нойрны цаг эхэллээ*” хэмээнэ. Энэ бол орчин цагийн сторитэлингийн аргуудын нэг юм.

Хүүхэд хөгшидгүй үдшийн ярьсан үлгэрийг шүүн тунгааж, сайныг нь ойлгож, мууг нь жигшин зүүдэндээ үлгэрээ үргэлжлүүлдэг нь нэг ёсондоо оюун ухааны “хичээл” болдог байжээ. Маргааш нь үлгэрээ үргэлжлүүлэн сонсохын тулд хүүхдүүд эртлэн босож өдрийн ажлаа зохицуулж сурч, хонь мал хариулахдаа өөр зуураа шүүн хэлэлцэж, үдэш үргэлжлүүлэн сонсоно.

**Монголчуудын түүхэн домог** (legend). Монгол домог бол товч тодорхой утга санаатай, эхлэл, өрнөл, тайлал бүхий богино хэлбэрийн уран яруу хүүрнэл зохиол болно. Домог нь үеэс үед уламжлагдахдаа аман түүхийн үүргийг гүйцэтгэж иржээ. Энэ бол монголчууд сторитэлингийн өнө эртний уламжлалтай байсны бас нэгэн жишээ юм.

Монгол түүхэн ба хууч домог үүсэн хөгжих эх үндэс нь хүн, байгаль, нийгмийн бодит юм үзэгдэл, үйл явдлаас сэдэв авсан байдаг. Мэдээж хэрэг уран санаа, уран сэтгэмжтэй байж аман зохиолын төрөл болно. Түүхэн болон аман домгуудын сэдэв өргөн буюу сургамжит түүх, шашны шүтлэг, түүхэн хүн, бурхад, хүн ба хүн бус төрхт, чөтгөр, шулам, сүг сүнс зэрэг гайхалтай сэтгэмжит дүрс, хий хүчнүүдтэй холбоотой адал явдлуудыг нь хамаарна.

Английн шашин судлаач Карен Армстронг “*Домог гэдэг нь нэг ёсондоо нэг удаа тохиолдсон боловч байнга давтагддаг үйл явдал юм. Бидний дассан түүхийн он цагийн хатуу хандлага нь ийм үзэгдлийг дүрслэх үг олохгүй байна*” (Armstrong, 2005) хэмээн домог бол хүний бодит байдлаа цэгцлэх, ойлгох арга замуудын нэг гэж улам бататгажээ. Тиймээс монголчуудын ан гөрөө амьтан агнахад биш харин уул хангайгаа аргадах, баясгах гэж явдаг байсан тул заавал нэг үлгэрчийг багтаа багтаадаг байжээ. Өөрөөр хэлбэл, хүн бүхэн ан гөрөө хийхгүй өөр тусгай үүрэгтэй хүнийг авч явж оройдоо түүдэг галаа тойрон уул хангай, тал хээрийн эзэд сахиусныг баясган домог түүх, хууч (old talk) яриулдаг сайхан уламжлалтай байжээ. Энэ бол монголчуудын эртний сторитэлингийн жинхэнэ чухал баримт юм.

Хууч яриа бол домгоос ялгаатай бас нэгэн төрөл билээ. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн аман зохиолын сан хөмрөгийн соронзон бичлэгийн сан одоогоор **13.54** цагийн домог **50.51** цагийн хууч яриа байна. Өнөөдөр бидэнд үлгэр, домог, хууч тэргүүтний ярьдаг хүн үндсэндээ байхгүй болж байхад Япон улсад үлгэрч (катарисю, ханасимоно) нар хэдэн тооны үлгэр мэддэг, ямар төрлийн үлгэр ярьдгаараа өрсөлддөг байна. Тэд 200-300 үлгэр мэдэгчийг энгийн үлгэрч гэх бол 500-600 үлгэр мэддэг бол алдар цуутай болдог нь уламжлал, заншлаа хадгалан хамгаалагч гэх утгаар гэр бүлийн хүрээнд үлгэрч эмээ, үлгэрч өвөө нар шиг ихээхэн нэр хүндтэй байдаг ажээ.

Дээрх бүхний ард ярих урлаг дээд зэргээр хөгжсөн, зарим тохиолдолд үе дамжсан авьяаслаг үлгэрч нар олон байсан нь тодорхой. Монгол үлгэрч, туульчид үлгэр ярих явцдаа тухайн үлгэрийн үйл явдлын дагуу жүжигчлэх, нүүр царайгаа хувиргах, дууны өнгөө өөрчлөх зэргээр сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлж

энгийн үг хэллэгээр, уран яруугаар хэлдэг байжээ. Ийнхүү уламжлалт үлгэр, тууль, домог сэлт нь олон мянган жилийн сорилыг даван туулж өнөө цагтай золгохдоо *уран сайхны үнэн* гэдэг шалгуурыг давсанд оршдог. Уран сайхны үнэн гэдэг нь “*гоо зүйн олон талт категори бөгөөд амьдрал, түүний дотоод мөн чанарыг утга төгс, зүй ёсоор нь ер бусын өвөрмөц, уран сайхны аргаар дүрслэн илэрхийлэх явдал юм*” (Лит. словарь, 1925: 1081-1082).

Мэдээллийн эринд амьдарч буй өнөө цагт “мэдээллийг бүтэцжүүлэх чадвар нэн шаардлагатай бөгөөд түүх гэдэг нь сэдэв, үзэл санаагаараа өөрийн гэсэн бүтэцтэй. Бид зөвхөн түүх бүтээх туршлагын тухай бус, түүнийг ярих, дамжуулах урлагийн тухай ярьж байгаа билээ” (Александрова, 2023: 7). Монгол үлгэрч, түүх яригчдын өвөрмөц онцлог нь домог түүх ярих гэдэг эмх замбараагүй, хэн нэгний хүсэлд хөтлөгдөх зүйл биш, харин үлгэр ярихад “сайн”, “муу” өдрийг сахидагт оршино. Монголчууд болон зарим үндэстэнд ч тийм ёс бий. Үүнийг судлаачид анзаарсан бөгөөд тухайлбал, “олонх ард түмний дунд үлгэр ярихыг хориглох, эсвэл эсрэгээр, ажил хөдөлмөрийн болон нийгмийн амьдралын тодорхой мөчид ярих ёс заншил” байдаг нь үлгэр ба үлгэрч, үлгэрч ба сонсогчдын холбоо нь далд ухамсрын түвшинд оршдог, үлгэрч буюу өгүүлэгч ярьж буй үлгэрээ, сонсогчид ч гэсэн үлгэр домгийг оюун санааны ид шидийн утгатай гэдгийг хадгалсаар байдаг (Померанцева, 1963, 10: 11). Тиймээс монголчууд үлгэр нь олон үеийг туулан дамжиж ирсэн өвөг дээдсийн үнэт өв гэхээсээ биднийг хамгаалагч, амьдралыг таниулагч ид шидтэй зүйл гэж үздэг нь үлгэрийг дутуу орхихгүй байх, эхлэл, төгсгөлийг онцгой анхаарч зүй ёсоор хэлэх зэргээс харагддаг. Үнэндээ үлгэр домог ярих гэдэг хүний сэтгэл санаа, сэтгэл хөдлөл, гоо зүй, ёс суртахуунтай шууд хамааралтай зүйл билээ. Үүнийг монгол сторитэлингийн уламжлал гэж үзэж хадгалж болох юм.

## Дүгнэлт

Энэ бүхнээс дүгнэн үзэхэд, монголчууд домог (миф), үлгэр, домог, хууч зэрэг сторитэлингийн баялаг өвтэй, түүнээ тодорхой хэмжээнд хадгалсаар ирсэн боловч гүйцэтгэх зан үйлийн орчин, үлгэрч, хуурчдын нөхцөл байдал зэрэг олон шалтгаанаар хүүрнэн хэлэх, ярьж өгүүлэх хэрэгцээ багассаар үлгэрч, үлгэр ярьдаг эмээ өвөө үгүйлэгдэх хэмжээнд хүрсэн байна.

Монгол Улс үлгэрийн бүртгэлийг олон улсын үлгэрийн бүртгэлийн системээр өнөө болтол хийгээгүйгээс уламжлалт үлгэрийн хувьд хүүхдэд ярих үлгэр, домог (миф) тэргүүтний насны ангилал, ялгаа заагийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоогоогүй. Энэ нь монгол үлгэр гадаадын үлгэр, зохиосон үлгэрт байр сууриа тавьж өгөх, үлгэрийг хамаа замбараагүй хэвлэх зэрэг нөхцөл болжээ.

Үлгэрч, хуурч, туульс нар нь зөвхөн уран сэтгэмжид тулгуурласан уран сайхны мэдээлэл болсон үлгэрийг ярьж хүүрнэх өгөхөөс гадна хүүхэд багачуудад үе тэнгийнхэн, ахимаг насны хүмүүстэй харилцах харилцааг хэрхэн бий болгохыг зааж өгдөг, эргэцүүлэн тунгаах, амьдралыг ойлгоход тустай нэгэн төрлийн багшийн үүрэг гүйцэтгэгч юм. Тийм ч учраас үлгэр ярих, сонсох явцад бий болдог нандин чанарыг орчин үеийн монголын нийгэмд зан үйлийн хэм хэмжээнд нөлөөлөхүйцээр сторитэлингийн түвшинд хүргэх, бүх нийтээр анхаарах шаардлагатай байна. Жишээлбэл, үлгэр бол хамтын үйл ажиллагааны зарчимд

тулгуурладаг тул нийгмийн гишүүдийн сонсох чадвар, бие биедээ хүлээцтэй байх чадварыг төлөвшүүлэхэд хувь нэмэр оруулдаг. Сонсох чадвар, сонсож сурах гэдэг өнөөдрийн нийгэмд ёс зүйн чухал элемент юм.

Уламжлалт үлгэрийг хүндэтгэдэг чанар монгол хүнд байдаг тул үлгэр ярих, түүнийг сонсох явцад бүрэлддэг амьд соёлын харилцаа, эерэг орчин, хамтын үйл ажиллагааны загварт түшиглэн хэл яриа, хандлага, өөрсдийн соёлоо дахин бэхжүүлж нийгмийн бүрийн салбар, бүлэгт нөлөөлөх байдлыг сторитэлингийг хөгжүүлэхийн зэрэгцээ хамтатган судлах шаардлагатай байна.

## Ном зүй

- Armstrong, David M.** (1992). *Managing by Storying Around*. New York: Bantam Doubleday Dell Publishing Group, Inc.
- Andy Gurevich** (2021). *World Mythology Myth, Metaphor and Mystery*. Gresham: MHCC Library Press.
- Александрова, М.Е.** (2023). *Мастерство литературно-сценический импровизации. Сторителлинг: Учебное пособие. 3-е издание*. Санкт-Петербург: Изд. “Планета музыки”. [Aleksandrova, M.Ye. *Masterstvo literaturno-stsenicheskiy improvizatsii. Storitelling: Uchebnoye posobiye. 3-ye izd.*]. [*Mastery of literary and scenic improvisation. Storytelling: A Study Guide. 3rd edition*]. St. Petersburg: Publishing house “Planet of Music”. 2023.]
- Мирча Элиаде.** (1996). *Мифы сновидения мистерии*. Москва-Киев: Изд. “Рефл-бук. Ваклер”. Перевод А.П.Хомика. [Mircha Eliade. *Mify snovideniia misterii*]. [*Myths, dreams and mysteries. Translation by A.P.Homika. Publishing house “Refl-buk. Vakler”*]. 1996.]
- Armstrong, Karen** (2005). *A Short Story of Myth*. Edinburg: Canongate Press.
- Бродский Н. и А. Лаврецкий.** (1925). *Словарь литературных терминов (Т.2)*. Москва-Ленинград: Изд. Л.Д.Френкель. [Slovar' literaturnykh terminov]. [Dictionary of Literary Terms. Ed by N.Brodskii. A.Lavretskii. Publishing house L. D. Frenkel. Moscow-Leningrad. 1925.]
- Померанцева Э.В.** (1963). *Русская народная сказка*. Москва: Изд. Академии наук СССР. [Pomerantseva E.V. *Russkaya narodnaya skazka*]. [Russian folk tales. Publishing house of the USSR Academy of Sciences. Moscow. 1963.]

### *Архивын материал:*

[УТА] Үндэсний төв архив. Ф-23, Д-2, ХН-87. 1953.Х.12. *ШУА. Хэл бичгийн кабинет.*



**Open access:** This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>